



ЗАВХАН АЙМГИЙН
ЭРДЭНЭХАЙРХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 20

Алтан

Г Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот Г
хуулийн этгээд байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2, 18.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, 77.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Хайрхан нутгийн хөгжлийн сан, сумын Засаг даргын Тамгын газрын харъяалалд байгаа халаалтын нэгдсэн систем, сумын төвийн ундны усны гурван худаг, халуун ус, "Алтан" зочид буудал, хог тээвэрлэх зориулалтын 2 автомашин, гал унтраах авто машин, ковш трактор зэрэг эд хөрөнгө дээр тулгуурлан "Эрдэнэхайрхан Хөгжил" нэртэй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот хуулийн этгээдийг байгуулсугай.

2."Эрдэнэхайрхан Хөгжил" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах техник тоног төхөөрөмж, эд хөрөнгөөр хангаж ажиллахыг Засаг дарга (А.Балжир)-т үүрэг болгосугай.

3. "Эрдэнэхайрхан Хөгжил" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот хуулийн этгээдийн дүрэмийг хавсралтаар баталсугай.

Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Х.БАЛЖИННЯМ